

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, заалт, хэсэг, тайлбар нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:

“3.4.Эмчилгээний зориулалтаар шавар, элсийг ашиглахтай холбогдсон харилцааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмаар зохицуулна.”

2/7 дугаар зүйлийн 7.5, 7.6 дахь хэсэг:

“7.5.Газар өмчлөгч, эзэмшигч нь өөрийн өмчлөл, эзэмшлийн газарт байгаа түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиг олох зорилгогүйгээр, өөрийн ахуйн хэрэгцээнд ашиглаж болно.

7.6.Улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ач холбогдолтой дэд бүтэц, авто зам, төмөр зам, барилгын салбарт ашиглагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах эрхтэй хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх болон байгаль орчны нөхөн сэргээх үүргээс чөлөөлөгдөхгүй.”

3/9 дүгээр зүйлийн 9.1.16 дахь заалт:

“9.1.16.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих тухай журмыг батлах;”

4/10 дугаар зүйлийн 10.1.19-10.1.26 дахь заалт:

“10.1.19.ил уурхайн аюулгүй байдлын дүрмийг батлах;
10.1.20.хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийг батлах;
10.1.21.ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй байдлын дүрмийг батлах;
10.1.22.ашигт малтмалын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журмыг батлах;”

10.1.23.алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад түшаах үлгэрчилсэн дүрмийг батлах;

10.1.24.тусгай зөвшөөрлийн бүртгэл хөтлөх журам батлах;

10.1.25.энэ хуулийн 20¹ дүгээр зүйлд заасан хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох журмыг батлах;

10.1.26.Монгол Улсын нутаг дэвсгэрт геологи, геохими, гидрогеологийн зураглал, геофизик, геоэкологи, минерагени, металлогений судалгаа болон төрөл бүрийн ашигт малтмалын хайгуулын ажлыг гүйцэтгэх заавруудыг батлах;”

5/11 дүгээр зүйлийн 11.1.26 дахь заалт:

“11.1.26.улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой ач холбогдолтой дэд бүтэц, авто зам, төмөр зам, барилгын салбарт ашиглагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг давуу эрхтэйгээр хайх, ашиглах эрхийг тухай бүр шийдвэрлэх;”

6/11¹ дүгээр зүйлийн 11¹.1.5 дахь заалт:

“11¹.1.5.Монгол Улсын геологийн судалгааны ажлын явц, үр дүнд үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх үүрэг бүхий Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийг байгуулах, түүний дүрмийг батлах.”

7/12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт:

“12.1.6.хүний эрүүл мэнд, байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалт болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих.”

8/13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт заасан “урьд нь уг талбайд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан” гэдэгт хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг эрх бүхий байгууллагаас бүхэлд нь эсхүл хэсэгчлэн нөөцөд буюу тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах үед уг талбайд хайгуулын ба ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон этгээд хамаарна.

-“үргэлжлүүлэн эзэмших давуу эрх” гэж тухайн талбайд урьд нь тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д зааснаас өөр болзол, шаардлагагүйгээр тусгай зөвшөөрлийг авахаар өргөдөл гаргах боломжийг хэлнэ.”

9/14 дүгээр зүйлийн 14.8 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт заасан “урьд нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан” гэдэгт хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг эрх бүхий байгууллагаас бүхэлд нь эсхүл хэсэгчлэн нөөцөд буюу тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах үед уг талбайд хайгуулын ба ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон этгээд хамаарна.

–“тэргүүн ээлжинд авах давуу эрх” гэдгийг урьд нь тухайн талбайд тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалтад оролцохгүйгээр тусгай зөвшөөрлийг эхлэн авах бололцоо гэж ойлгоно.”

10/20 дугаар зүйлийн тайлбар:

“Тайлбар:-Энэ зүйлд заасан “бичгээр мэдэгдэх” гэж төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр эсхүл түүний үтгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргасан этгээдэд гардуулсан буюу хүргүүлснийг хэлнэ.”

11/20¹ дүгээр зүйл. Хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох

“20¹.1.Энэ хуулийн 7.1-д заасан шаардлага хангасан этгээд энэ хуулийн 9.1.11-т заасан хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицол тогтоож, нийтэд мэдэгдсэн талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл авах өргөдөл гаргах бөгөөд түүнд хайгуул хийх талбайн байршил, түүний булангийн цэгийг төрийн захиргааны байгууллагаас гаргасан нэг загварын газрын зураг дээр тэмдэглэж, солбицлуудыг градус, минут, секундээр тодорхойлж хавсаргана.

20¹.2.Өргөдөлд дурдсан хайгуулын талбай энэ хуулийн 17.5 ба 17.7-д заасан шаардлагыг хангасан байна:

20¹.3.Өргөдөлд дурдсан хайгуулын талбай энэ хуулийн 17.6-д заасан нөхцлийг хангасан байна:

20¹.4.Энэ хуулийн 20¹.1, 20¹.9.2-т заасан шаардлага хангасан бөгөөд хамгийн түрүүнд өргөдөл гаргаж бүртгүүлсэн этгээдэд хайгуулын тусгай зөвшөөрөл олгоно.

20¹.5.Энэ хуулийн 20¹.4-т заасан этгээд хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг батлагдсан маягтын дагуу төрийн захиргааны байгууллагад гаргах бөгөөд түүнд түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

20¹.5.1.энэ хуулийн 18.1.1, 18.1.2, 18.1.3, 18.1.6-д заасан баримт бичиг;
20¹.5.2.энэ хуулийн 20¹.1-д заасны дагуу хийгдсэн талбайн зураг ба тухайн зураг дээр тэмдэглэсэн уг талбай байрших аймаг, сум, дүүргийн нэр;
20¹.5.3.хайгуулын ажил эрхлэх мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан талаархи мэдээлэл.

20¹.6.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20¹.5-д заасан өргөдлийг хүлээн авмагц дор дурдсан ажиллагаа явуулна:

20¹.6.1.өргөдлийг өргөдөл бүртгэх дэвтэрт бүртгэж өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийн хуудас тус бүрт бүртгэлийн он, сар, өдөр, цаг, минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэж, энэ тухай тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх;

20¹.6.2. тухайн өдөр хамгийн түрүүнд болон сүүлд бүртгэгдсэн өргөдөлд тусгай тэмдэглэгээ хийх;

20¹.6.3. бүртгэсэн даруйд нь өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 20¹.1, 20¹.2, 20¹.3, 20¹.5-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд анхан шатны шүүлт хийх;

20¹.6.4. энэ хуулийн 20¹.6.3-т заасан анхан шатны шүүлт хийсний дараа хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон буюу түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай давхцаж байгаа эсэхийг тогтоох.

20¹.7. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20¹.6-д заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

20¹.7.1. өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 20¹.1, 20¹.2, 20¹.5-д заасан шаардлагыг хангаагүй бол хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж шалтгаан, үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх;

20¹.7.2. хүсэлтэд дурдсан талбай нь энэ хуулийн 20¹.6.4-т заасан талбайтай давхцаагүй бол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтойг мэдэгдэх;

20¹.7.3. хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцсан бол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжгүйг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх;

20¹.7.4. хүсэлтэд дурдсан талбай нь түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай бүхэлдээ давхцсан бол тусгай зөвшөөрөл олгох боломжгүйг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх;

20¹.7.5. хүсэлтэд дурдсан талбай нь түрүүлж ирүүлсэн өргөдөлд тусгагдсан талбайтай хэсэгчлэн давхцсан бол давхцаагүй хэсэгт нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтойг мэдэгдэх бөгөөд өргөдөл гаргасан этгээд уг талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлттэй байгаа бол энэ тухай дахин өргөдөл гаргах.

20¹.8. Энэ хуулийн 20¹.7.2, 20¹.7.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн бол Төрийн захиргааны байгууллага тухайн талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг мөн хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөх тухай өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.

20^{1.9}.Энэ хуулийн 20^{1.8}-д заасан шийдвэр гаргаснаас хойш өргөдөл гаргасан этгээд 1 сарын дотор тусгай зөвшөөрлийг аваагүй, эсхүл эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөөгүй бол төрийн захиргааны байгууллага өргөдлийг бүртгэлээс хасч өргөдөл гаргасан этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэж өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэнэ.

20^{1.10}.Өргөдөл гаргасан этгээд эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлсөн бол төрийн захиргааны байгууллага ажлын 3 өдөрт багтаан хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

20^{1.11}.Хайгуулын тусгай зөвшөөрөлд энэ хуулийн 20.6-д заасан тэмдэглэл, хавсралттай байна.

20^{1.12}.Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

20^{1.13}.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20^{1.7.1}, 20^{1.7.3}, 20^{1.7.4}, 20^{1.9}-д заасан шийдвэр гаргасан бол өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг өргөдөл гаргасан этгээдэд буцааж өгнө.

12/20¹ дугаар зүйлийн тайлбар:

“Тайлбар:-Энэ зүйлд заасан “бичгээр мэдэгдэх” гэж төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр эсхүл түүнийг утгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргасан этгээдэд гардуулсан буюу хүргүүлснийг хэлнэ.”

13/26 дугаар зүйлийн 26.1.1 дахь заалтын тайлбар:

“Тайлбар:-Энэ заалтад “тодорхойлолтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх” гэж холбогдох баримтыг хүсэлт гаргасан этгээдэд гардуулах буюу хүргүүлснийг хэлнэ.”

14/26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт заасан “мэдэгдэнэ” гэдэгт төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр эсхүл түүнийг утгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд гардуулах буюу хүргүүлж, түүнийгээ баримтжуулсан байхыг ойлгоно.”

-Дээрх тайлбар нь 26 дугаар зүйлийн 26.3.2 дахь хэсгээс бусад заалтад хамаарна.”

15/28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт “мэдэгдэнэ” гэдэгт төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр эсхүл түүнийг үтгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд гардуулах буюу хүргүүлж, түүнийгээ баримтжуулсан байхыг ойлгоно.”

16/30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт “мэдэгдэнэ” гэдэгт төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр эсхүл түүнийг үтгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд гардуулах буюу хүргүүлж, түүнийгээ баримтжуулсан байхыг ойлгоно.”

17/39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт “мэдэгдэнэ” гэдэгт төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр эсхүл түүнийг үтгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд гардуулах буюу хүргүүлж, түүнийгээ баримтжуулсан байхыг ойлгоно.”

18/51 дүгээр зүйлийн 51.7 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт “мэдэгдэнэ” гэдэгт төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр эсхүл түүнийг үтгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд гардуулах буюу хүргүүлж, түүнийгээ баримтжуулсан байхыг ойлгоно.”

19/51 дүгээр зүйлийн 51.8 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт “мэдэгдэнэ” гэдэгт төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр эсхүл түүнийг үтгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд гардуулах буюу хүргүүлж, түүнийгээ баримтжуулсан байхыг ойлгоно.”

20/56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт “мэдэгдэнэ” гэдэгт төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр эсхүл түүнийг үтгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд гардуулах буюу хүргүүлж, түүнийгээ баримтжуулсан байхыг ойлгоно.”

21/56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт “мэдэгдэнэ” гэдэгт төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр эсхүл түүнийг үтгыг агуулсан албан бичгийг өргөдөл гаргагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд гардуулах буюу хүргүүлж, түүнийгээ баримтжуулсан байхыг ойлгоно.”

22/62 дугаар зүйлийн 62.6 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт “мэдэгдэнэ” гэдэгт төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны шийдвэр эсхүл түүнийг үтгыг агүүлсан албан бичгийг өргөдөл гаргагчид болон тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдэд гардуулах буюу хүргүүлж, түүнийгээ баримтжуулсан байхыг ойлгоно.”

23/26 дугаар зүйлийн 26.3.1 дэх заалтын тайлбар:

“Тайлбар:-Энэ заалтад “бичгээр мэдэгдэх” төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр эсхүл түүний үтгыг агүүлсан албан бичгийг өргөдөл гаргасан этгээдэд гардуулсан буюу хүргүүлснийг хэлнэ.”

24/26 дугаар зүйлийн 26.3.4 дэх заалтын тайлбар:

“Тайлбар:-Энэ заалтад “бичгээр мэдэгдэх” төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр эсхүл түүний үтгыг агүүлсан албан бичгийг өргөдөл гаргасан этгээдэд гардуулсан буюу хүргүүлснийг хэлнэ.”

25/26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийн тайлбар:

“Тайлбар:-Энэ хэсэгт “бичгээр мэдэгдэх” төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр эсхүл түүний үтгыг агүүлсан албан бичгийг өргөдөл гаргасан этгээдэд гардуулсан буюу хүргүүлснийг хэлнэ.”

26/27 дугаар зүйлийн 27.1.14 дах заалт:

27.1.14. Олборлосон түүхий эд, баяжмал, бүтээгдэхүүнээ ашигт малтмалын гаралтай түүхий эд, баяжмал боловсруулах, ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг дотоодын аж ахуй эрхлэгчдэд шаардагдах хэрэгцээг буюу дотоодын зах зээлийн хэрэгцээг хангаж, олон улсын зах зээлийн үнээр худалдсаны дараа экспортлох.”

27/27 дугаар зүйлийн 27.2, 27.3, 27.4 дэх хэсгүүд:

“27.2. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.14-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд олборлосон түүхий эд, баяжмал, бүтээгдэхүүнээ экспортлох эрхгүй.

27.3. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.14-д заасан үүргээ биелүүлсэн эсэхэд хяналт тавих журмыг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

27.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.14-д заасан үүргээ биелүүлээгүй гэж үзвэл аж ахуй эрхлэгч гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гомдол гаргах эрхтэй бөгөөд уг гомдлыг шийдвэрлэсэн шийдвэрийг эс зөвшөөрвөл захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргаж болно.”

28/34¹ дүгээр зүйл:Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон

ашиглалтын тусгай зөвшөөрөл

“34^{1.1}.Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь доор дурдсан төлбөр төлнө:

34^{1.1.1}.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 100 төгрөг, хоёр дахь жилд 200 төгрөг, гурав дахь жилд 300 төгрөг, дөрвөөс тав дахь жилд тус бүр 1000 төгрөг;

34^{1.1.2}.түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн 0-20 гектар тутамд 5000 төгрөг, 30 гектар хүртэл 8000 төгрөг, 50 гектар хүртэл 10000 төгрөг, 100 гектар хүртэл 15000 төгрөг, 200 гектараас дээш 20000 төгрөг.”

29/44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэг:

“44.2.Ашигт малтмалын ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд нь энэхүү хуулийн 10.1.19-10.1.21-т заасан аюулгүй байдлын дүрмүүдийг мөрдөж ажиллана.”

30/47¹ дүгээр зүйл. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр:

“47^{1.1}.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт төлнө.

47^{1.2}.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2.5 хувьтай тэнцүү байна.

47^{1.3}.Энэ хуулийн 47^{1.2}-т заасан төлбөрийн хувь хэмжээг тухайн түгээмэл тархацтай ашигт малтмалын тархац, шинж чанар, байгаль орчинд нөлөөлөх байдлыг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.”

31/47⁴. Цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр:

“47^{4.1}.Цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үүрхэйн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн цацраг идэвхт бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнээс тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсөвт төлнө.

47⁴.2.Энэ хуулийн 47⁴.1-д заасан борлуулалтын үнэлгээг дараахь журмаар тооцно:

47⁴.2.1. экспортод бүтээгдэхүүн гаргасан бол олон улсын худалдаанд хүлээн зөвшөөрөгдсөн тухайн сарын дунджийг тогтоох зарчмыг үндэслэн тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнийг баримтлан;

47⁴.2.2.дотоодод борлуулсан буюу ашигласан бол тухайн бүтээгдэхүүний, эсхүл түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн үнийг үндэслэн;

47⁴.2.3.дотоодын ба олон улсын зах зээлд борлуулсан бүтээгдэхүүний зах зээлийн жишиг үнийг тодорхойлох боломжгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдүүлсэн борлуулалтын орлогыг үндэслэн.

47⁴.3.Цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дараахь хэмжээтэй байна:

47⁴.3.1.цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн доод хэмжээ нь тухайн үүрхэйн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5,0 хувьтай тэнцүү.

47⁴.3.2.тухайн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлтөөс хамаарч энэ хуулийн 47⁴.3.1.-д заасан хувь дээр нэмэлт төлбөрийн хувийг нэмсэн дүнгээр тооцож, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулах бөгөөд нэмэлт төлбөрийн хувийг дараахь байдлаар тодорхойлно:

Дэс дугаар	Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллар аар	Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувь		
					Хүдэр	баяжмал	бүтээгдэхүүн
1	Уран	кг	Ураны ислийн баяжмал	0-70 хүртэл	0	0	-
				70-100 хүртэл	3.0	1.0	-
				100-130 хүртэл	4.0	2.0	-
				130-160 хүртэл	5.5	3.5	-
				160-190 хүртэл	7.0	5.0	-
				190-210 хүртэл	8.5	6.5	-

				210-240 хүртэл	10.0	8.0	-
				240-270 хүртэл	11.5	9.5	
				270-300 хүртэл	13.0	11.0	
				300-с дээш	14.5	12.0	

47⁴.4.Засгийн газар өргөн мэдүүлж, Улсын Их Хурал баталснаар цацраг идэвхт ашигт малтмалын зөвшөөрөл эзэмшигч компани дахь төрийн эзэмшлийн хувь хэмжээг цацраг идэвхит ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж болно.

47⁴.5.Цацраг идэвхт ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тухайн ордын онцлог, зах зээлийн үнийн түвшингээс хамаарч, 9 хувиас хэтрэхээргүй байхаар Засгийн газар батална.”

32/56 дугаар зүйлийн 56.9 дэх хэсэг:

“56.9.Энэ хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасан хугацаанд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдөл гаргасан тохиолдолд энэ зүйлийн 56.2-56.8 дахь хэсэг нэгэн адил үйлчилнэ.”

2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний дараа “холбогдох бусад хууль” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “байдлаараа байгаа” гэсний дараа “болон хүдрийн овоолго, хаягдал, байгалийн усанд агуулагдаж байгаа” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалтын “саналыг үндэслэн” гэсний дараа “өргөдөл ба сонгон шалгаруулалтаар олгогдох” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “ажлыг” гэсний дараа “төлөвлөх” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.16 дахь заалтын “тусгай зөвшөөрөл” гэсний дараа “хүссэн” гэж, 11.1.25 дахь заалтын “олгох боломжтой” гэсний дараа “өргөдлийн болон” гэж, 11.3 дахь хэсгийн “гүйцэтгэнэ.” гэсний дараа “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага нь хяналт шалгалтын хүрээнд хяналтын улсын байцаагчийн эрх үүргийг хэрэгжүүлж болно.” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “нийтэд” гэсний дараа “ажлын 5 хоногт багтаан өдөр тутмын сонинд нийтэлж” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “босго үнийн зөрүү” гэсний дараа “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.5-д заасан үйлчилгээний хөлсийг” гэж, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “хангаагүй” гэсний дараа “бөгөөд энэ хуулийн 22.1-д заасан баримт бичгийг бүрэн ирүүлээгүй” гэж, 27 дугаар зүйлийн 27.1.13 дахь заалтын “төрийн захиргааны” гэсний дараа “болон нутгийн захиргааны” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалт:

“9.1.7.Ашигт малтмалын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу тодорхой газрыг нөөц, Газрын тухай хуулийн 16.1.5-16.1.8-д заасны дагуу тусгай хэрэгцээнд авах асуудлыг шийдвэрлэх, эсхүл энэ талаархи саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.”

2/12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт:

“12.1.4. Газрын тухай хуулийн 20.1.3-т заасан эрхийг хэрэгжүүлэх;”

3/42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалт:

“42.1.1.Стратегийн ач холбогдол бүхий ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар энэ хуулийн 42.1-д заасан гэрээг аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулна. Стратегийн ач холбогдол бүхий ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс бусад ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тус гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулна.”

4/61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэг:

“61.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9-д заасны дагуу шимтгэлийн сан байгуулна.”

4 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “эдгээртэй” гэснийг “тэдгээртэй” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Барилгын” гэснийг өмнө “Зам болон барилгын” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “сонгон шалгаруулалтын” гэснийг “өргөдлийн ” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “улсын тусгай хамгаалалттай газарт” гэснийг “газрыг улсын тусгай хамгаалалтаас гаргасны дараа” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтын “энэ хуулийн 5.5, 5.6-д” гэснийг “энэ хуулийн 5.4, 5.5-д” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалтын “тооцох” гэснийг “хянаж хүлээн авах” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтын “тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт” гэснийг “тусгай зөвшөөрөл өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар олгох үйл ажиллагааг” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “11.1.23” гэснийг “11.1.26” гэж, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Тусгай хэрэгцээний газарт” гэснийг “Тусгай хамгаалалттай болон тусгай хэрэгцээний газарт” гэж, 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсгийн “хяналтын албанд” гэснийг “хяналтын байцаагчид” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь заалтын “орчныг хамгаалах” гэснийг “орчны менежментийн” гэж, 35 дугаар зүйлийн 35.2.3 дахь заалтын “албаар” гэснийг “байгууллагаар” гэж, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “Байгаль орчны албанаас” гэснийг “Аймаг, нийслэлийн байгаль орчны газраас” гэж, 38 дугаар зүйлийн 38.1.5 дахь заалт, 38.3, 38.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “орчны менежментийн” гэснийг “орчныг хамгаалах” гэж, 38 дугаар зүйлийн 38.1.1, 38.1.5 дахь заалтын “байгаль орчны хяналтын алба” гэснийг “аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага” гэж, 38 дугаар зүйлийн 38.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.1.6 дахь заалтын “байгаль орчны хяналтын албанд” гэснийг “аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад” гэж, 39 дүгээр зүйлийн 39.1.7 дахь заалт, 39.7 дахь хэсгийн “алба”

гэснийг “байгууллага” гэж, мөн зүйлийн 39.1.9 дэх заалтын “9.8” гэснийг “9.9” гэж, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн “төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж” гэснийг “шинэчлэн боловсруулсан төлөвлөгөөг” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “болон түгээмэл тархацтай” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.1.25 дахь заалтын “эдийн засгийн үр ашигтай” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.1.26 дахь заалтын “геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагаас” гэснийг, 9 дүгээр зүйлийн 9.1.11 дэх заалтын “энэ хуулийн 24.1-д зааснаас бусад тохиолдолд” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1.16 дахь заалтын “асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтын “болон түгээмэл тархацтай ашигт малтмалын” гэснийг, 11.1.16 дахь заалтын “олгох сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.19, 11.1.20 дахь заалтын “түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.25 дахь заалтын “батлуулах” гэснийг, 17 дугаар зүйлийн гарчигийн “шалгаруулалтын” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын үрилгыг” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “1 сарын” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “2-оос доошгүй жилийн” гэснийг, 38 дугаар зүйлийн 38.1.1 дэх заалтын “орчныг” гэснийг, 38 дугаар зүйлийн 38.1.4 дэх заалтын “байгаль орчны менежментийн”, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн “шинэчлэн боловсруулж” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ... –ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.5 дахь заалтад доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“25.1.5. 1. “тусгай зөвшөөрөл шинээр авахыг хүсч гаргасан өргөдлийг хянан үзэх...” гэснийг “...тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан болон сонгон шалгаруулалтад шалгарсан оролцогчид тусгай зөвшөөрөл олгох”

2 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсгийн гарчигийн “эзэмшүүлэхэд” гэсний өмнө “ашиглуулах,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг:

“7.5. Энэ хуулийн 15.10.2, 15.10.15-д заасан тусгай зөвшөөрөлтэй холбогдох журмыг хүнд үйлдвэрийн асвдал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын эрх олгосоноор батална.”

2/15 дугаар зүйлийн 15.10.23 дахь заалт:

“15.10.23. түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах.”

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчилсөн найруулсугай.

“11.3. Энэ хуулийн 15.10.5, 15.10.6-д заасан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицлын талаар аймаг, нийслэлийн Засаг даргаас Ашигт малтмалын тухай хуулийн 17.1, 17.2-д заасан журмын дагуу санал авсан байна.”

3 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“22.1.12.Ашигт малтмалын тухай хуулийн 17.2-д заасны дагуу санал хүргүүлэх;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсгийн “тухайн жилийн” гэсний дараа “байгаль хамгаалах төлөвлөгөө болон” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “хайх” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

7 дугаар зүйлийн 7.3.18 дахь заалт:

“7.3.18.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр.”

2 дугаар зүйл.Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.9 дэх заалтыг хүчингүй болсон тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2018 оны __ дугаар сарын __-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 2018 оны __ сарын __-ны дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шинэчлэн бүртгүүлнэ.

2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөө шинэчлэн бүртгүүлэх тухай өргөдлийг гаргасны дараа 30 хоногийн дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг, тусгай зөвшөөрөл олгосноос хойшхи хугацааны тайлан, төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг даргаас татан авч, тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн бүрдэл бүрэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгоно.

3 дугаар зүйл.2018 оны __ дугаар сарын __-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө аймаг, нийслэлийн Засаг даргын олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бүртгэхдээ геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ердийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөс ялгасан тэмдэглэгээ хийнэ.

4 дүгээр зүйл.Энэ хуульд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг цуцалж, тухайн талбайд Ашигт малтмалын тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулж, тусгай зөвшөөрлийг шинээр олгож болно.

5 дугаар зүйл.2018 оны __ дугаар сарын __-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүсч аймаг, нийслэлийн Засаг даргад ирүүлсэн өргөдлийг Ашигт малтмалын тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

6 дугаар зүйл.2018 оны __ дугаар сарын __-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө аймаг, нийслэлийн Засаг даргын олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах нэрээр өөр төрлийн ашигт малтмал хайж, ашигласан нь тогтоогдсон бол тусгай зөвшөөрлийг цуцалж, тухайн талбайд Ашигт малтмалын тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалт явуулж, тусгай зөвшөөрлийг шинээр олгоно.

7 дугаар зүйл.Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.34, 4.1.35 дахь заалт:

“4.1.34. “ялгасан талбай” гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны хэтийн төлөвтэй гэж үзэн хайгуул хийхээр газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тодорхойлсон талбайг;

4.1.35. “хөрөнгө оруулалт, хайгуулын ажлын доод хэмжээ” гэж бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан тухай жилд заавал хийж гүйцэтгэх ажлыг.”

2/31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэг:

“31.4. Засгийн газарт ногдох түүхий тосны жил бүрийн борлуулалтын орлогын гурван хувийг газрын тосны салбарыг хөгжүүлэх санд төвлөрүүлнэ.”

3/42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсэг:

“42.6. Гэрээлэгч нь байгалийн хий илэрсэн талаар Төрийн захиргааны байгууллагад 15 өдрийн дотор мэдэгдээгүй бол уг талбайд байгалийн хий ашиглуулахаар нээлттэй сонгон шалгаруулалт зарлана.”

2 дугаар зүйл. Газрын тосны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29 дэх заалтын “газрын тос” гэсний дараа “болон уламжлалт бус” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтын “газрын тосны бүртгэл, тооцоо” гэсний дараа “газрын тосны салбарыг хөгжүүлэх сан” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “хүсэлтээ” гэсний дараа “30 хоногийн дотор” гэж, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн “хэмжээ нь” гэсний дараа “олборлосон уламжлалт бус газрын тосны” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Газрын тосны тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.17, 4.1.18 дахь заалт:

“4.1.17. “бүтээн байгуулалт” гэж Монгол улсын нутаг дэвсгэрт олборлолтын байгууламж, дамжуулах хоолой, дэд бүтэц барихыг;

4.1.18.“олборлолт” гэж бүтээн байгуулалтаас бусад олборлохтой холбогдсон бүх үйл ажиллагааг;”

2/4 дүгээр зүйлийн 4.1.32, 4.1.33 дахь заалт:

4.1.32.“өртөгт газрын тос болон уламжлалт бус газрын тос” гэж газрын тосноос энэ хуулийн 4.1.31-д заасан зардлыг нөхөхөд зориулж энэ хуулийн 32.3-т заасан хувиар тооцсон газрын тос болон уламжлалт газрын тос;

4.1.33.“ашигт газрын тос болон уламжлалт газрын тос” гэж хүргэлтийн цэг дээр хэмжсэн нийт газрын тосноос энэ хуулийн 4.1.26, 4.1.32-т заасан газрын тос болон уламжлалт газрын тос хасаад Засгийн газар болон гэрээлэгчийн хооронд хуваах газрын тосыг”.

3/19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалт:

“19.1.5.энэ хуулийн 12 дугаар зүйлд зааснаар тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан эсхүл 11.1.5, 17.7 –д заасан нөхцөл үүссэн;”

4/30 дугаар зүйлийн 30.6 дахь хэсэг:

“30.6.Тусгай зөвшөөрлийн төлбөрийг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.12, 23.6.9, 23.8.13-т заасны дагуу хуваарилна.”

5/31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг:

“31.3.Нөөц ашигласны төлбөрийг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.11, 59 дүгээр зүйлийн 59.1.5-д заасны дагуу төвлөрүүлнэ.”

5/42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг:

“42.1.Хайгуулын явцад байгалийн хий илэрсэн тохиолдолд төрийн захиргааны байгууллагад 15 өдрийн дотор мэдэгдэх бөгөөд тухайн гэрээлэгчтэй байгалийн хийн талаар тусад нь гэрээ байгуулж болно.”

4 дүгээр зүйл.Газрын тосны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль болон түүнтэй” гэснийг “энэ хууль, холбогдох бусад хууль болон тэдгээртэй” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.29 дахь заалтын “үйл ажиллагааны зардал” гэснийг “олборлолтын зардал” гэж, 4.1.31 дэх заалтын “үйл ажиллагаа” гэснийг “олборлолт” гэж, 17 дугаар зүйлийн 17.3.4 дэх заалтын “хайгуулын хөрөнгө оруулалтын” гэснийг “хөрөнгө оруулалт, хайгуулын ажлын доод” гэж, 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “Байгаль орчинд нөлөөлөх” гэснийг “Байгаль орчны нөлөөллийн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.4.5 дахь заалтын “тэмдэглэсэн зураг” гэснийг “тэмдэглэн шав тэмдэг байршуулсан зураг” гэж, 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсгийн “өмнө төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.” гэснийг “дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлж, эхний улиралд багтаан батлуулна.” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Газрын тосны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.12 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны ... дүгээр сарын ... –ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “2/газрын хэвлий, ашигт малтмал” гэсний дараа “газрын тос, уламжлалт бус газрын тос” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.7, 4.1.8, 4.1.9, 4.1.10, 4.1.11, 4.1.12, 4.1.13 дахь заалт:

“4.1.7.“шатахуун” гэж тээврийн хэрэгсэлд хэрэглэгдэх бүх төрлийн автобензин, дизелийн түлш, керосин, онгоцны түлшийг;

4.1.8..“шатдаг хий” гэж байгалийн хий буюу метан хий, шингэрүүлсэн шатдаг хий буюу пропан, бутан болон этан хий зэрэг нүүрсустөрөгчийн хийг;

4.1.9.“тусгай шингэн” гэж тээврийн хэрэгслийн эд ангид хэрэглэгдэх хөргөлтийн шингэн, гидрийн, тормозны зэрэг бусад шингэнүүд;

4.1.10.“шатахууны улсын нөөц” гэж улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тасалдал, хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Засгийн газраас тогтоосон нэр төрөл, тоо хэмжээний дагуу бүрдүүлсэн улсын болон аж ахуйн нэгжийн агуулахад хадгалагдаж байгаа шатахууныг;

4.1.11.“улсын экспертиз буюу улсын магадлан шалгалт” гэж Барилгын тухай хуульд заасныг”;

4.1.12.“газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа” гэж шатахуун, шатдаг хийг түгээх станцаар борлуулахыг ;

4.1.13.“газрын тосны бэлэн бүтээгдэхүүн” гэж газрын тос, байгалийн хий болон химийн нэгдлүүдийг боловсруулах замаар гарган авсан холбогдох стандарт, техникийн шаардлагыг хангасан үйлдвэрлэлийн эцсийн шатны газрын тосны бүтээгдэхүүнийг;

4.1.14.“газрын тосны завсрын бүтээгдэхүүн” гэж газрын тос, байгалийн хий болон химийн нэгдлүүдийг боловсруулах үйлдвэрлэлийн явцад дараагийн шатны боловсруулалтад орох нэрлэгийн бүтээгдэхүүнүүд буюу хагас боловсруулсан нүүрсустөрөгчийн химийн нэгдлүүдийг.”

2/5 дугаар зүйлийн 5.2.6, 5.2.7, 5.2.8, 5.2.9, 5.2.10 дахь заалт:

“5.2.6.шатдаг хийн импорт, худалдаа, тээвэрлэлт, түгээлт, хадгалалтын үйл ажиллагааг зохицуулах журам баталж мөрдүүлэх;

5.2.7.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам баталж мөрдүүлэх;

5.2.8.газрын тосны бүтээгдэхүүний чанарт хяналт тавих журам баталж, мөрдүүлэх;

5.2.9.газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний болон жижиглэнгийн худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар санал, дүгнэлт гаргах газрын тосны бүтээгдэхүүний мэргэжлийн зөвлөл байгуулах;

5.2.10."газрын тосны бүтээгдэхүүний мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм баталж мөрдүүлэх."

3/6 дугаар зүйлийн 6.1.10 дахь заалт:

"6.1.10.газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтад чанарын хяналт хийх."

4/7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт:

"7.3.Газрын тосны завсрын бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр импортлох бөгөөд тус тусгай зөвшөөрлийг газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдэд олгоно."

5/8 дугаар зүйлийн 8.5 дахь заалт:

8.5.Үйлдвэрлэлийн технологи, үйл ажиллагаагүйгээр, боловсруулалтын бус аргаар газрын тосны завсрын бүтээгдэхүүнийг шууд холих, найруулах замаар бүх төрлийн шатахуун үйлдвэрлэх, гарган авахыг хориглоно.

6/9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт:

9.4.Газрын тосны завсрын бүтээгдэхүүнийг шууд холих, найруулах замаар гарган авсан үндэсний стандарт, техникийн шаардлага хангаагүй бүтээгдэхүүнийг шатахуун нэрээр худалдан, борлуулахыг хориглоно."

2 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "энэ хууль" гэсний дараа "болон холбогдох бусад хууль" гэж, 5 дугаар 5.2.3 дахь заалтын "холбогдсон" гэсний дараа "аюулгүй ажиллагаа, техник ашиглалт, хэвийн хорогдол, хөдөлмөр, эрүүл ахуйн" гэж, "норм" гэсний дараа "аргачлал, зааврыг" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн дараахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт:

"4.1.1."газрын тосны бүтээгдэхүүн" гэж газрын тос, байгалийн хий болон химийн нэгдлүүдийг боловсруулах замаар гарган авсан шатахуун, шатдаг хий, тусгай шингэн, тос тосолгооны материал, мазут, битум болон бусад бүтээгдэхүүнийг;"

2/9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалт:

“9.3.2.чанар стандартын шаардлага хангасан газрын тосны бэлэн бүтээгдэхүүн худалдах”;

4 дүгээр зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “хуулийн этгээдэд” гэснийг “хуулийн этгээд, төрийн байгууллагад” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “газрын тосны бүтээгдэхүүний” гэснийг “шатахууны” гэж, мөн зүйлийн 5.2.1 дэх заалтын “хадгалалт” гэснийг “хадгалалтын” гэж, мөн зүйлийн 5.2.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “шатахууны” гэснийг “шатахуун, шатдаг хийн” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “барьж байгуулах” гэснийг “барих, өргөтгөх” гэж, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “эзэмшигч” гэснийг “хүсэгч” гэж, мөн зүйлийн 8.3.3 дахь заалтын “улсын экспертизийн” гэснийг “улсын экспертиз буюу улсын магадлан шалгалт” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “Газрын тосны бүтээгдэхүүний” гэснийг “Шатахууны” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “Төрийн хяналт, шалгалтын тухай хууль” гэснийг “Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, холбогдох бусад хуулийг” гэж, 12 дугаар зүйлийн гарчигийн “бүтээгдэхүүний” гэснийг “бүтээгдэхүүнтэй” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын “үйлдвэрлэл” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.2.1 дэх заалтын “хөрөнгө оруулалт” гэснийг 11 дүгээр зүйлийн 11.4.3 дахь заалтын “дамжуулах” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

7 дүгээр зүйл.Энэ хуулийг 2018 оны ... дүгээр сарын ... –ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “дизель түлш” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**АЖ АХУЙ НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын “түлш” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГОЛ МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ
ХАЙХ, АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний дараа “болон холбогдох бусад хууль” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “гадаргын урсацын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс, сав газрыг ” гэснийг “Усны тухай хуулийн 3.1.5-д заасныг” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “Усны тухай хуулийн 31.3-т заасныг” гэснийг “Усны тухай хуулийн 3.1.9-т заасныг” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2018 оны ... дүгээр сарын ... –ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг